Golomt Capital®
Delivering diversity

Interactive Brokers

# ТОЙМ



## ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

2024.05.20

*Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв*

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

## ТОВЧ

2024 он 05-р сарын 20

- АНУ-ын хэрэглээний индекс эдийн засагчдын хүлээлтээс бага буюу 0.3% гарлаа.
- Инфляц буурч байгаатай холбогдуулан ам.доллар суларч, ам.доллартай харьцаж байгаа алт, хувьцаа гэх мэт бүтээгдэхүүний ханш өслөө.
- АНУ-ын жижиглэнгийн борлуулалт өнгөрсөн сард өөрчлөлтгүй гарч ХНС-гийн авч хэрэгжүүлж буй арга хэмжээ үр дүнгээ өгч байгааг харууллаа.
- Хятадын ардын банк үл хөдлөх хөрөнгийн салбараа дэмжихийн тулд орон сууцны зээлийн урьдчилгаа төлбөрийн хувийг бууруулжээ. Мөн ипотекийн зээлийн хүүгийн доод хэмжээ арилгаж, хотын удирдлагууд өөрсдөө тогтоох эрхийг олгожээ.

| | |
|---|---|
| Dow Jones | 40,003.59 |
| S&P 500 | 5,303.27 |
| Nasdaq | 16,685.97 |
| DAX | 18,707.28 |
| FTSE 100 | 8,420.26 |
| S&P/ASX 200 | 7,814.4 |
| HANG SENG | 19,553.61 |

### АНУ-ын индексийн өгөөж

| Индекс | Өдрийн | Долоо хоног | Сар | Жилийн эхнээс | Жил | 3 жил |
|---|---|---|---|---|---|---|
| Dow Jones | 0.34% | 1.45% | 5.31% | 6.14% | 19.68% | 16.94% |
| S&P 500 | 0.12% | 1.57% | 6.77% | 11.18% | 26.51% | 27.61% |
| Nasdaq | -0.07% | 1.82% | 9.19% | 11.16% | 31.82% | 23.87% |

2024 оны 05 сарын 20-ны 13:30



### Европын индексийн өгөөж

| Индекс | Өдрийн | Долоо хоног | Сар | Жилийн эхнээс | Жил | 3 жил |
|---|---|---|---|---|---|---|
| DAX | -0.17% | -0.15% | 5.47% | 11.67% | 14.94% | 21.18% |
| FTSE 100 | -0.22% | 0.06% | 6.64% | 8.88% | 8.55% | 19.98% |

2024 оны 05 сарын 20-ны 13:30



### Ази Номхон далайн индексийн өгөөж

| Индекс | Өдрийн | Долоо хоног | Сар | Жилийн эхнээс | Жил | 3 жил |
|---|---|---|---|---|---|---|
| S&P/ASX 200 | 0.67% | 1.50% | 3.95% | 3.63% | 8.06% | 11.89% |
| Hang Seng | 0.61% | 3.15% | 21.53% | 15.67% | 1.37% | -30.71% |

2024 оны 05 сарын 20-ны 13:30



# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

**АНУ-ЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

АНУ-ын тэргүүлэх гурван индекс бүх цаг үеийн түүхэн дээд ханшдаа ойртож ирлээ. Өнгөрсөн саруудад хэрэглээний үнийн индекс таамаглалын дагуу буурч чадахгүй байсан ч саяхан зарлагдсан 4 сарын хэрэглээний үнийн индекс хүлээлтээс бага гарч зах зээлд эерэг нөлөөг авчирлаа.

Өнгөрсөн Пүрэв гарагийн жижиглэнгийн борлуулалтын тоо буурсан нь хэрэв эдийн засагт муу нөлөөтэй мэдээ боловч инфляц болон хөрөнгийн зах зээл сайн мэдээ гэж үзэж болно.

4 сарын жижиглэнгийн борлуулалтын датанд хэрэглэгчид өөрсдийн үзэмжээр зардлаа танаж, дэлгүүрээс гадуурх (ихэвчлэн онлайн) жижиглэнгийн худалдаа эрхлэгчдийн борлуулалт 1.2%-иар буурч, мөн ресторан, баарны борлуулалт бага зэрэг буурсан байна.

Инфляцийн буурсан үзүүлэлтүүд нь АНУ-ын 10 жилийн хугацаатай төрийн сангийн өгөөж сүүлийн нэг сар гаруйн хугацааны доод түвшинд хүрлээ.

**График 1: Ам.долларын ханшийн төлөв байдал ба техник шинжилгээ**




Өнгөрсөн долоо хоногт АНУ-ын зах зээл дээр хэрэглээний үнийн индекс болон жижиглэнгийн борлуулалтын үзүүлэлт зарлагдсан. Тус 2 үзүүлэлт нь хоёул ам.доллар индекст хүчтэй нөлөөг үзүүлдэг. Инфляц буурч, жижиглэнгийн борлуулалт удааширч байгаа нь хөрөнгө оруулагчдад ХНС удахгүй бодлогын хүүгээ бууруулах найдварыг төрүүлснээр ам.долларын ханш өнгөрсөн долоо хоногт 1 орчим хувиар уналаа. Техник шинжилгээний үүднээс 4 сарын эхэнд тогтсон хамгийн сүүлийн өндөр ёроолтой зэрэгцэн ирж дэмжлэг авах магадлал өндөр байна. Хэрэв тухайн цэгээс (104.300) амжилттай дэмжлэг авч чадвал өсөлтөөр 105.964 хүрэх боломжтой.

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

**БНХАУ-ЫН ЗАХ ЗЭЭЛ**

БНХАУ-ын Ардын Банк орон сууцны урьдчилгаа төлбөрийн харьцааг анхны худалдан авалтын хувьд 20 хувиас 15 хувь хүртэл бууруулсан бол хоёрдогч худалдан авалтын хувьд 25% болгож бууруулсан байна. Түүнчлэн ипотекийн зээлийн хүүгийн доод хэмжээг цуцлан хотын удирдлагууд хэмжээг нь өөрсдөө тогтоох эрхийг нь олгох юм. Нэмэлтээр, БНХАУ-ын Төв банк 300 тэрбум юанийг орон нутгийн байгууллагуудад зарагдаагүй орон сууцыг худалдаж авахад туслах зорилготой зээл олгохоор төрийн өмчит банкуудад нийлүүлнэ.

Хятадын эдийн засаг дефляцид өртөх боломжтой байсаар байна. Тухайлбал, энэ оны 4-р сард хэрэглээний үнийн индекс өмнөх жилтэй харьцуулбал 0.3 хувиар өссөн нь 3-р сарын дататай харьцуулбал 0.1 хувийн өсөлт юм. Харин үйлдвэрлэгчийн үнийн индекс 2.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

**График 2: BABA хувьцааны ханшийн график ба техник шинжилгээ**




Alibaba Group Holdings Хонконгийн хөрөнгийн бирж дээр анхдагч бүртгэлтэй хувьцаагаа байршуулах төлөвлөгөөтэй байгаа бөгөөд энэ үйл явц нь 8-р сард эцэслэгдэнэ гэсэн хүлээлттэй байна. Alibaba компанийн хувьд хувьцаа нь эх газрын Хятадын хөрөнгийн биржүүдэд бүртгэлгүй бөгөөд HKEX дээр анхдагч бүртгэл үүсгэснээр Stock Connect системээр дамжин эх газрын Хятадын хөрөнгө оруулагчдыг татах боломжтой болно. Эх газрын Хятадын хөрөнгө оруулагчид энэ жил эхэлснээс хойш Хонконгийн хөрөнгийн зар зээлд HKD 233.5 тэрбум оруулсан нь Hang Seng индексийн өсөлтөд нөлөөлөөд байна. Одоогоор тус компани нь 82 компанийн бүрэлдэхүүнтэй Хонконгийн Hang Seng индексийн 3 дахь томоохон компани бөгөөд тус индекст 7.5 хувийн жинг эзэлдэг байна.

Түүнээс гадна, Саудын Арабын Public Investment Fund (PIF) болон алдарт Майкл Бьюрри-ийн Scion Asset Management Alibaba дахь эзэмшлээ нэмэгдүүлсэн байна. 3-р сарын байдлаар PIF 20.5 тэрбум ам.долларын үнэ бүхий 38 хувьцаа эзэмшиж байсан бол Scion Asset Management оны сүүлээр 95 гаруй тэрбум ам.долларыг удирдаж байсан нь 15 хувьцаанаас бүрдэж байжээ.

# ТАЙЛАНГИЙН ХУАНЛИ

### Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд




### Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

